



ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 69

Хэрлэн сум

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Өлзийт тосгоны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (69,75) авсан Баатарпүрэвийн Цэрэнлхамыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Өлзийт тосгоны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшигч Б.Цэрэнлхамыг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Э.Хонгорзул)-д зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА